

**В.Т.ТЕПКЕЕВ, КАЛМЫКИ В СЕВЕРНОМ ПРИКАСПИИ ВО
ВТОРОЙ ТРЕТИ XVII ВЕКА (XVII ЗУУНЫ ЭХЭН ХАГАСЫН
КАСПИЙН УМАР НУТАГ ДАХЬ ХАЛИМАГУУД)**

Цонгоол Б.Нацагдорж

ОХУ-ын Хальмг Тангч улсын нийслэл Элст (*ор.Элиста*) хотод орших Оросын ШУА-ийн харьяа Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгээс 2012 онд тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан В.Т.Тепкеевийн *Калмыки в Северном Прикаспии во второй трети XVII века* (XVII зууны эхэн хагасын Каспийн умар нутаг дахь халимагууд) нэгэн сэдэвт зохиолыг Джангар хэвлэлийн газарт хэвлүүлсэн байна¹. Зохиогч Владимир Толтаевич Тепкеев нь ОХУ-ын ШУА-ийн харьяа Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн ахлах эрдэм шинжилгээний ажилтан бөгөөд 1975 онд Элст хотод төрсөн, 2002 онд Халимагийн улсын их сургуулийн Хүмүүнлэгийн сургуулийн түүхийн ангийг дүүргэж, 2005 онд Оросын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнд Ph.D докторын зэрэг хамгаалан одоог хүртэл Халимагийн хүмүүнлэгийн судалгааны хүрээлэнгийн түүх археологийн салбарт эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллаж буй.

Тус зохиол нь нийт гурван бүлэг бөгөөд өмнөх үг, дүгнэлтийн хамт 24 хэвлэлийн хуудас буюу бүгд 375 хуудас болно. Үүнд,

Нэгдүгээр бүлэг: Каспийн умар нутагт халимагууд суурьшиж эхэлсэн ба түүний урьдач нөхцөл (Халимагууд өрнө зүгт нүүдэллэж эхэлсэн нь; Каспийн умард тал нутагт халимагуудын анх нэвтэрсэн нь; 1625-1630 оны хоорондох дотоодын самуурал; Далай баатарын(дөрвөдийн Далай тайш) Каспийн умард тал нутагт суурьших оролдлого; 1630-1635 оны үеийн Дайчины(торгуудын Шүхэр дайчин) бодлого; 1635-1640 оны үеийн халимагуудын нутаг)

Хоёрдугаар бүлэг: Каспийн умар нутагт халимагуудын суурьшсан нь 1640-1657 (1640-өөд оны эхэн дэх халимагуудын хөрш ард түмнүүдтэй харилцсан байдал; Халимагийн нийгэм дэх 1642-1643 оны улс төрийн хямрал; Халимагуудын умард Кавказад довтолсон нь; Халимагийн нийгэм дэх хямрал; 1645 оны Орос-Халимагийн хэлэлцээр; Зая бандидын морилсон нь; 1645-1647 оны хоорондох халимагуудын нутаг; Дайчины эргэж ирсэн нь; Крымд довтолсон нь; 1649 оны шахаа тангараг; Хошуудын өрнө зүгт нүүдэллэсэн нь;

1. В.Т.Тепкеев. Калмыки в Северном Прикаспии во второй трети XVII века. Элиста, 2012.

1648-1649 оны Халимаг-Башкирийн харилцаа; Астраханийг довтолсон нь; Иван Онучины элчээр ирсэн нь; Дайчины засаглал бэхжсэн нь; Луузаны Крымд довтолсон нь; 1651-1654 оны Орос-Халимагийн хэлэлцээр; Орос-Халимагийн харилцаа болон 1655 оны шахаа тангараг; Зая бандидын хоёрдугаар айлчлал; 1657 оны шахаа тангараг)

Гуравдугаар бүлэг: Каспийн умар нутаг дахь халимагууд 1657-1672 оны хооронд (1657-1661 оны Орос-Халимагийн хэлэлцээр; Иван Горохов нар элчээр ирсэн нь; Халимагийн элч Москвад очсон нь; 1661 оны шахаа тангараг; Мончакийн(торгуудын Шүхэр дайчины хүү Пунцаг) засаглал бэхжсэн нь; Башкирийн бослого; Орос-Польшийн дайнд халимагуудын оролцсон нь; Мончак болон Орос-Халимагийн хэлэлцээр; Степан Разины бослого; Халимагийн нийгэм дэх улс төрийн хямрал болон Аюукийн засгийн эрхэнд гарсан нь)

Уг номд Монголын ойрад аймгууд XVII зууны эхээр дотоодын хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өмнөд Сибириэр дамжин Каспийн тэнгисийн умард тал нутагт хүртэл хэрхэн аажмаар нүүдэллэж очсон, тэр нутгийн түрэг хэлтэн нүүдэлчдийг эзлэн авч алба авах болсон, Москвагийн хаант улстай харилцаж, улмаар Каспийн умард тал нутагт бүрэн суурьшиж хаант улсыг байгуулсан тухай тус зууны 70-аад оныг хүртэл түүхчлэн өгүүлжээ.

Тухайлбал, **Нэгдүгээр бүлэгт**, Каспийн тэнгисийн умард тал нутагт суурьших зорилгоор хамгийн анх нүүдэллэж ирсэн ойрадууд бол түүх бичлэгт тогтсончлон Хоо өрлөг тэргүүтэй торгууд нар бус харин эх өөртэй дүү Байбагастаа дотоодын самуунд ялагдаж 1628 онд баруун зүгт албатаа аван дүрвэж ирсэн хошуудын Чокур буюу Цөөхүр нарын бүлэг байсан ба тэдний дараагаар дөрвөдийн Далай баатар тайш албатын хамтаар энэ нутагт суурьшихаар нүүдэллэж ирсэн боловч Эмба, Зай мөрний дагуу суухыг хориглосон оросын эсэргүүцэлтэй тулж хуучин нутагтаа буцсаны дараагаар л сая 1630 оны намар торгуудын бүлэг Арал тэнгис, Эмба, Зай мөрний орчмоор ирж нутагласан тухай өгүүлэв. Зохиогч энэхүү сүүлийн бүлгийн нүүдлийг ойрадын доторх бүлгүүдийн өрсөлдөөнөөс үүдсэн гэж үзжээ. Энэхүү бүлэгээс мөн торгууд нарын Ижил, Зай мөрний завсар суурьшин нутаглах эцсийн шийдвэрийг Шүхэр дайчин тууштай хэрэгжүүлсэн болохоос эхэн үедээ ойрадын бусад бүлгүүдийнхээ ойр нутаглахыг эрмэлзэж байсан Хоо өрлөгийн гүйцэтгэсэн үүрэг төдий л их бус болохыг мэдэж болно. Гэхдээ тод үсгийн сурвалжуудад дурдсан шиг 1630 буюу 1632 онд торгууд нар нэг л дор Ижил мөрөн Астрахань хотын орчим хүрч нутагласан явдал байсангүй бөгөөд энэ үед Шүхэр дайчины толгойлсон торгуудын бүлэг Зай(ор.Яик) мөрний зүүн эргээс Арал тэнгисийн хооронд нутаглаж Ижил мөрний орчим суурьшихаар цэрэг дайны үйл ажиллагаа явуулж түрэг хэлтэн нүүдэлчдийг довтлох буюу өөртөө татаж оруулж авч байжээ. Гэтэл

Өмнөд Сибирьт төвлөрч байсан ойрадын бүлэгийг толгойлсон дөрвөдийн Далай баатар тайш буддын шашны том лам нараар дэмжүүлэн торгууд нарыг буцаж хуучин нутагтаа ирэх, оруулж авсан татар, ногайчуудыг тэгш хуваах, Шүхэр дайчины дэргэд хоргодсон хошуудын Чокурыг(Шүхэр дайчины хадам эцэг) гаргаж өгөх шаардлага тавьж хүчтэй шахалт үзүүлсэн байна. 1635 онд Далай баатар тайш нас барснаар энэ дайсагналцал суларч улмаар Хоо өрлөг, Дайчин нар 1640 оны чуулганд оролцож, Өмнөд Сибирьт байсан ойрадуудын хамтаар нутаглах болсон ч торгууд нарын нэг хэсэг нь Шүхэр дайчингийн дүү нарын удирдлаган дор Каспийн умард тал нутагт байсаар байсан бөгөөд энэ нутагт нэгэнт суурьшихаар шийдсэн байжээ.

Хоёрдугаар бүлэгт, Дөрвөдийн Далай баатар тайшийн хатан бага хатан, Хоо өрлөгийн охин Субундай болон түүнээс төрсөн хүү Соломцэрэн нар Далай тайшаас хамгийн бага өмч хүртсэн ч хамгийн их өмч иргэн олсон Соломцэрэнгийн эх Субундайг хатан болгон авснаар түүний албат иргэдийг нь мэдэх болсон Дайчин хошуучаас зугтаж Хоо өрлөгийн өмгөөллийг эрсэнд 1642 онд торгууд дөрвөдийн хооронд дайн дэгдэж Дайчин хошууч тэргүүтэй дөрвөдийн таван тайш алагдсан ба торгууд нар болон Соломцэрэнгийн толгойлсон дөрвөд нар 1630-аад оны сүүлээр Зай мөрний орчим үлдэж хоцорсон торгууд нартай очиж нийлсэн нь торгууд нар Каспийн умард тал нутагт бүрмөсөн суурьших нөхцөл болсныг өгүүлжээ. Үүнээс өмнө зөвхөн цэргийн хүчээр оруулан авч байсан ногайчууд 1643 онд сайн дураараа торгуудын тайш нарын захиргааг хүлээж тэдэнтэй хамт нутаглах болсон Оростой харилцах харьцааг хурцатгаж улмаар энэ асуудлыг цэргийн хүчээр шийдвэрлэхээр оролдсон Хоо өрлөг нар Умард Кавказад хийсэн аян дайны үеэр алагдаж, 1644 онд нь оросууд халимагуудыг цэрэглэсэн нь ойрадын энэ бүлгийн байдлыг улам хүндрүүлсэн боловч Өмнөд Сибириэр төвлөж байсан “*чакарские калмыки*” нараас тусгаар байх эрмэлзэл, Орос Европыг Дундад Азитай холбосон гол замыг хянах эдийн засгийн ашиг сонирхол нь илүү давамгайлж тэднийг энэ нутагт уяж байсан аж. Энэ үеэр Төвдийг дайлахад оролцоод Зүүнгарын Баатар хунтайжийн дэргэд байсан Шүхэр дайчин Далай ламаас хан цол хүртэж 1647 онд Ижилийн зүг буцаж ирмэгц Оростой харилцаагаа сайжруулахаар оролдож эхэлсэн нь Хасагийн Жахангир хантай холбоотон бололцсон хошуудын Хөндлөн увш, дөрвөдийн Даян Омбо нар зүүнгарын Баатар хунтайжтай байлдаж ялагдаад 1649 онд торгууд нарын зүг нүүдэллэн ирснээр нутаг бэлчээрийн асуудал хурцадсантай бас давхар холбогдсон байна. Ойрадууд Ижил, Доны зүг нүүдэллэн орж ирэхийг Оросын засгаас хүлээн зөвшөөрөхгүй байсан боловч удалгүй тэдний цэргийн хүчийг өөрийн гол дайсан Крымийн хаант улсын эсрэг ашиглах бодлого явуулснаар Орос-Халимагийн харилцаа хэвийн хэмнэлд орж эхэлжээ. Гэхдээ Оросын төв засгийн газраас өмнө 1648 онд Доны хасагуудтай (ор. казак) эхэлж цэргийн холбоо байгуулсан нь сонирхолтой бөгөөд чухам

энэ холбоо Оросын засгийн газрын халимагийн талаар явуулсан бодлогыг цаашид тодорхойлж өгөв. Оросын засгийн газар халимагуудыг дагаар орох шахаа тангараг өргөсөн тохиолдолд л Ижилийн хоёр эргээр чөлөөтэй нутаглах, Оросын хотуудад худалдаа хийхийг зөвшөөрөх нөхцөл тулгаж байсан ч халимагууд тэрхүү шахаа тангарагийг холбоо байгуулсан гэрээ гэж ухаарч байсан нь баримт бичгүүдээс тодорхой харагдах бөгөөд 1654 онд дэгдсэн Орос-Польшийн дайнд Польшийн холбоотон болсон Крымийн эсрэг халимагуудыг ашиглахаар зарим буулт хийснээр 1655-1657 оны хооронд халимагийн тайж нар нийтдээ 3 удаа шахаа тангараг өргөсөн нь бүгд тодорхой эрх үүргийг хоёр этгээдэд хариуцуулсан байна.

Гуравдугаар бүлэгт, Орос болон Османы эзэнт улсын өрсөлдөөний талбар болсон Умард Кавказ, Крым, Каспийн умард тал нутагт ойрадууд ямар тоглолт үзүүлж байж сая хэл, соёл, гарал ондоотой улс түмний дунд өөрийн оршин тогтнох эрхээ олж авсныг Халимаг-Крым, Халимаг-Оросын харилцааны баримтууд дээр тулгуурлан цааш нь өгүүлжээ. 1650-иад оноос хойш тогтмолжсон Халимаг-Крымийн харилцаа болон Крымийн хааны баялаг бэлэг сэлт зэрэг нь Оростой харилцахад ашиглах гол хөшүүрэг болж байв. Халимаг-Оросын харилцааг шинэ түвшинд гаргахад Умард Кавказын кабардинчуудын ноён бөгөөд Астраханий алмууд болсон Григорий Черкасский болон түүний ач дүү Каспулат Черкасский нар ихээхэн үүрэг гүйцэтгэж Мончакийн хүү Аюкад өөрийн охин дүү Обелханаг өгч худ ураг бололцсон нь халимагийн ноёдоос барьцааны хүн шаардаж байсан өмнөх бодлогоосоо татгалзаж, Халимаг-Оросын харилцаанд хувийн харилцааг ашиглахаар хичээж эхэлсний илрэл болж 1661 оны эцсээр халимагийн ноёд дахин шахаа тангараг өргөсөн нь Крымийн хаант улсын эсрэг чиглэсэн цэргийн холбооны гэрээтэй илүү төстэй байжээ. Өөрсдийн холбоотон болгосон халимагуудыг Ижилийн баруун эрэг Дон орчимд нутаглахыг Оросын засгийн газраас уриалах болсон нь Крымийн хаант улсын эсрэг чиглүүлсэн бодлого байсан агаад 1650-иад оноос хойш сая халимагуудын Ижилийн адгаар нутаглах хожмын нутаг нь тодорхой болсон байна. Зохиогч шинээр судалгааны эргэлтэнд оруулсан баримтуудаас үзвэл халимагийн тайж нар Орос-Польшийн дайнд Москвагийн талд оролцохдоо Крымийн хаант улсыг мөхөөх эхсхүл Умард Кавказ, Хар тэнгисийн умард эргээс тэднийг шахан гаргах зорилтыг дэвшүүлж байсан гэж үзсэн байна. Гэвч энэхүү төлөвлөгөө нь зүүн зүгээс нүүдэллэж ирсэн хошуудын Аблай нарын довтолгооноос болж тасалдсан бөгөөд ялагдал хүлээсэн торгуудын тайж нар Доны зүг ухран орж, дотоодын самууралд автаж зарим хэсэг нь Крымийн талд орсон ч Мончакийн хүү Аюка дотоодын самууныг дарж гараад хошуудын Аблай нарыг ялж албатыг нь хурааж авснаар Ижил мөрний эрэг дээр өөрийн өвгө Шүхэр дайчины суурийг нь тавьсан Халимагийн хаант улсыг үндэслэн байгуулсан нь Хөхнуураар төвлөж байсан Хошуудын

хаант улсаас гадна мөн яг энэ үеэр эмхлэгдэн байгуулагдсан Зүүнгар улсын нэгэн адилаар XVIII зуунд мөхөх хүртлээ ойрадуудын улс төрийн гол чиг баримжаа болж байжээ.

Владимир Тепкеев ерөнхийдөө энэхүү номыг Москвад байх Оросын эртний түүхийн баримтын архивт (РГАДА) ажиллаж цуглуулсан, урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй шинэ баримт сэлтэнд түшиглэн бичсэн тул өмнөх үеийн судалгааг багагүй урагш ахиулж, нэг шинэ шатаар дэвшүүлсэн гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй. Ялангуяа торгууд болон дөрвөдийн ноёдын араб үсгээр татар болон перс хэлээр бичсэн захидал бичгүүдээс гадна худам монгол, тод үсгээр монгол хэлээр бичсэн захидал бичгүүдийг анх удаагаа уг эхээр нь хэвлэн нийтлүүлж судалгааны эргэлтэнд оруулсан нь ихээхэн чухал зүйл боллоо. Ойрадын торгууд, дөрвөд, хошууд аймгууд Ижил, Зай мөрний сав нутагт хүрч нутаглахдаа ногой, башкир, татар, туркмен, каракалпак, хасаг зэрэг нүүдэлчид болон кабарда, черкес зэрэг Кавказийн улс төдийгүй Крымийн татарын хаант улс, Перс, Оттоманы эзэнт улс, Польштой өргөн харилцах болсон тул тэдний түүхэнд холбогдох баримт Оросын эртний түүхийн баримтын архивын зөвхөн Калмыцкий фонд буюу Халимаг хөмрөгт л хадгалагдаж үлдсэн биш мөн ногой, башкир, кабарда, черкес, Крым зэрэг газар оронтой Оросын харилцсан баримтуудыг агуулсан бусад хөмрөгүүдэд мөн үлэмж тоотой хадгалагдаж буйг Халимаг-Крымийн харилцааг судалсан өмнөх судалгааныхаа² явцад соргоогоор анзаарч улмаар холбогдох баялаг материалуудыг цуглуулснаар урьд үеийн судлаачдын дутууг нөхөж, ялангуяа Халимаг-Орос, Халимаг-Кавказ төдийгүй Ойрадын дотоод харилцааны бүдэг түүхийг тодруулж чадсан байна.

Зохиогч энэхүү бүтээлдээ дүгнэснээр XVII зууны эхэнд ойрадууд дотроо хэд хэдэн бүлэглэл болон хуваагдаж дээд эрх мэдлийн төлөө өрсөлдөж байсан бөгөөд тэдгээр нь зөвхөн нэг овог аймгаас бүрдсэн бус харин улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан ихээхэн өөрчлөгдөж хувирсан бүтэцтэй байж, нэг аймаг бүлэг дотроо хуваагдаж хоёр тал болон дайсагналцах зэргээс шалтгаалан Каспийн тэнгисийн умард тал нутагт нүүдэллэн ирсэн ойрадуудын дотор торгуудаас гадна дөрвөд хошууд мөн нилээд тоотой оролцжээ. Халхын баруун гарын Алтан хааны түрэлтээс үүдэн Өмнөд Сибирь одоогийн умард Казахстаны зүг шахагдсан дөрвөн ойрадын олон аймгуудаас торгуудын ноёдын толгойлсон Ижил, Зайн бүлэг, цорос язгуурт ноёдын толгойлсон зүүнгарын бүлэг, Гүүш хаан нарын толгойлсон хошууд, торгуудын Хөхнуурын бүлэг тус тус салсан бөгөөд эхэндээ дөрвөдийн Далай баатар тайшийн толгойлж байсан, орос сурвалжид *чакарские калмыки* хэмээх нэрээр тэмдэглэгдсэн хамгийн том бүлэг нь Далай баатар тайшийн сүүлээр хошуудын ноёдын мэдэлд оров.

2. Калмыцко-крымские отношения в начале XVIII века // 48-я сессия Постоянной международной алтаистической конференции (PIAC). Москва: ИВ РАН, 2005. с. 86

Дон, Ижил мөрөн Уралын нуруунаас өмнөш Каспийн тэнгисийн умард тал нутагт Халимагийн хаант улс үүсч бүрэлдсэн нь цорос угсааны дөрвөдийн Далай баатар тайшийн төвлөрсөн засаглал явуулахаар оролдсон бодлогын эсрэг хандсан торгууд ноёдын эрмэлзлээс анх үүдэж улмаар энэ үйл явц нь 1647 онд Шүхэр дайчинг хан өргөмжилснөөс эхлэн 1697 онд Оросын засгийн газар түүний ач Аюкийн хан цолыг хүлээн зөвшөөрөх хүртэл үргэлжилжээ.

Судлаач өмнөх үеийн эрдэмтдийн төдийлөн хүрч хамарч чадаагүй баялаг архивын хэрэглэгдхүүнд тулгуурлан ойрадын нэг хэсэг нь хэрхэн Ижил мөрний сав газарт хүрч нутаглан улмаар хаант улсыг байгуулж, олон улсын тавцанд өөрсдийгөө хүлээн зөвшөөрүүлж, оршин тогтнох болсон түүхийг эмх цэгцтэйгээр дараалуулан нэгэн шугаманд зангидаж өгсөн нь урьд үеийн судлаачдын бүтээлд илэрч байсан нилээд дутуу зүйлсийг түүхэн учир шалтгааны хувьд ухаж ойлгоход дөхөмтэй болгосон байна гэж үзнэ. Харин орос хэлний архивын эх хэрэглэгдхүүнийг хангалттай сайн ашиглаад зогссонгүй, халимагийн ноёдын Оростой харилцсан албан бичгийн бодит эхүүдийг олж анх удаагаа нийтлүүлсэн боловч харин тэдгээр сурвалжаа бодитоор ашиглаж судалгаандаа хэрэглэсэнгүй нь нилээд харамсалтай. Жишээлбэл, халимагийн ноёдын татар болон перс хэлээр бичсэн захидлуудын эрдэм шинжилгээний галиг болон орчуулгыг хийсэнгүй зөвхөн тухайн үеийн маш муу, хэт нэг талыг баримталж өөрийн биеийг өргөж бусдыг дарсан орос орчуулгыг л дагалдуулсан байна.³ Тэр ч байтугай монгол хэлээр үйлдсэн халимаг ноёдын захидлуудыг нэгээс бусдыг нь мөн уг эхээс нь орчуулсангүй⁴, аанай л тухайн үеийн муу орос орчуулгыг барьсан байх нь Халимаг-Оросын харилцааг ойрад ноёдын нүдээр харах боломжийг нь хааж өгчээ. Гэвч зохиогчийн өөрийнх нь бичсэнээс үзэхүл энэхүү ном нь XVII зууны ойрад-халимагийн түүхийг судалсан судалгааны ажлын гурван үндсэн чиглэлийн нэгийг нь л үр дүн бөгөөд цаашид тус зууны эхэнд ойрадууд Өмнөд Сибирьт нүүдэллэн орсон үйл явц болон тус зууны төгсгөлийн Аюки ханы үеийн Халимагийн хаант улсын тухай дараачийн судалгааны ажлуудыг бичиж гаргахаар чармайж байгаа гэх тул тэрхүү дараачийн бүтээлүүддээ монгол хэлний сурвалжийг зохистойгоор ашиглаж, нэг талын мэдээ баримтанд хэт баригдах зовлонгоос ангижрах буй за хэмээн найдна.

3. В.Т.Тепкеев. Калмыки в Северном Прикаспии во второй трети XVII века. Элиста, 2012. с.127;154; 275-276; 295

4. В.Т.Тепкеев. Калмыки в Северном Прикаспии во второй трети XVII века. Элиста, 2012. с.270; 293-294

А.В.ИГУМНОВ - ПЕРВЫЙ ИРКУТСКИЙ МОНГОЛОВЕД.**Ю.В.Кузьмин**

Александр Васильевич Игумнов (1761-1834) – известный иркутский знаток монгольского и бурятского языков, один из первых в России составителей рукописного 4-х томного монголо-русского словаря, переводчик и преподаватель монгольского языка в Иркутске, Верхнеудинске. Он является учителем основателя российского научного монголоведения О.М.Ковалевского.

Полная творческая биография А.В.Игумнова до сих пор не написана и ждет своего исследователя. Отдельные стороны его творческого наследия представлены в публикациях Н.Щукина (1838), В.В.Вагина (1872), Н.И.Веселовского (1879), П.П.Баснина (1902), Л.С.Пучковского (1960), М.П.Хамаганова (1961), Ш.Б.Чимитдоржиева (1980, 1997) и др.¹ Краткие сведения о нем имеются также в известных российских энциклопедиях и словарях.

Его работы и краткие сведения о нем были опубликованы в журналах: “Казанские известия” (1816), “Вестник Европы”(1822), “Сибирский вестник”(1828), “Московский телеграф”(1828-1829). Очерк жизни и деятельности А.В.Игумнова был опубликован в журнале “Сын Отечества” и “Северный архив”².

А.В.Игумнов родился в Кударинской крепости, находящейся на границе с Китаем. Его отец служил здесь переводчиком монгольского и маньчжурского языков. Детство прошло среди бурят и монголов, поэтому он хорошо говорил на их языках. В 1771 г. отец отдал его в только что учрежденную школу монгольского языка в Селенгинске, которую окончил в 1777 г. Затем он идет по стопам своего отца и служит толмачем в Кяхтинской пограничной канцелярии, в 1781-1782 гг. в качестве переводчика сопровождает в Китай Российскую духовную миссию. Постоянно совершенствует собственные познания восточных языков, внимательно наблюдает жизнь различных народов Китая и Монголии, собирает этнографические и фольклорные

1. Пучковский Л.С. Александр Васильевич Игумнов, Очерки по истории русского востоковедения. Сборник III. М., 1960, с.166-195, Чимитдоржиев Ш.Б. Монголовед А.В.Игумнов, Исследования по культуре народов Центральной Азии. Улан-Удэ, 1980. с.155-160.

2. Щукин Н. А.В.Игумнов. Сын Отечества и Северный Архив. Т.П. СПб., 1838, отд.3. с.84-96.

сведения. За интерес к китайской и монгольской литературе и культуре в Иркутске его называли “мандарином”. Начинает формироваться пытливым исследователь монгольских народов.

При содействии иркутского губернатора Ф.Н.Клички он смог отправиться в Москву и Петербург, где работает в архивах и библиотеках, встречается с учеными. Особенно внимательно изучал литературу о Монголии и монгольских народах. Видимо, именно здесь он принимает решение о необходимости составления монголо-русского словаря. В 1786 г. в связи с осложнением обстановки на русско-китайской границе его отзывают из столицы и А.В.Игумнов принимает деятельное участие в разрядке напряженности.

Затем он служит в различных городах Сибири: Иркутске, Верхнеудинске, Кяхте, Чите. В Иркутске служил переводчиком монгольского языка при Общем губернском управлении. Занимался переводческой и преподавательской деятельностью. А.В.Игумнов в совершенстве овладел монгольским и бурятским языками, пользовался высоким авторитетом у местных коренных жителей. В 1813 г. учредил частную монгольскую школу. Также преподавал монгольский язык в Иркутской духовной семинарии. А.В. Игумнов сумел убедить иркутского архиепископа Михаила в необходимости ввести преподавание монгольского языка в духовной семинарии. Преподаванием монгольского языка он занимался на протяжении всей своей жизни, причем часто безвозмездно.

Таким образом, мы видим, что А.В.Игумнов не имел высшего образования и соответствующей научной и методической подготовки, а являлся практическим знатоком монгольских языков, своеобразным самородком, выходцем из простого народа, а его деятельность была ответом на потребности того времени.

По своим общественно-политическим взглядам являлся просветителем, был знаком и дружен с декабристами, находившимися в сибирской ссылке, принадлежал к просвещенным кругам сибирского общества. Известно, что в десятилетия вокруг монголиста А.В.Игумнова группировался небольшой кружок иркутской интеллигенции. Иркутский купец и библиофил П.Т.Баснин в мемуарах отмечал, что в городе нет “столь высоко ценимого всеми за мудрость, великое знакомство с существом всяких событий и доброту безконечную”.

Историки Ф.А.Кудрявцев и Г.Вендрих писали об этом так: “Среди противников “сибирских сатрапов” были талантливые представители немногочисленной тогда сибирской интеллигенции Г.С.Батеньков, монголист и китаевед А.В.Игумнов, писатель И.Т.Калашников, историк П.А.Словцов. В Иркутске вокруг Игумнова образовался небольшой кружок

людей, недовольных деспотическими действиями Пестеля, Трескина и др. чиновников. На Игумнова поступали доносы, что его гости сильно осуждают власти и “смеются над особой” генерал-губернатора. О злоупотреблениях местной администрации Игумнов сообщал своим друзьям в Петербург, прося их повлиять на улучшение сибирских дел”³.

Его дополняет другой известный историк И.В.Щеглов: “По словам старожила С.С.Щукина, Трескин не мог видеть, чтобы печатали что-либо из Иркутска в газетах, а особенно о ценах на хлеб, которые он выставял по-своему. Ему не хотелось, чтобы кто-нибудь вел переписку с Петербургом и, заподозрив, например, в этом монголиста Игумнова, образованнейшего человека своего времени, его начали притеснять, отдали под суд, отрешили от должности и запретили въезд в Иркутск”⁴.

За свои взгляды, убеждения и поступки А.В.Игумнов неоднократно подвергался преследованиям: находился под полицейским надзором, несколько раз высылался из Иркутска, был вынужден менять место работы и жительства. Эти обстоятельства существенно затрудняли его научную деятельность, сбор и составление словаря.

А.В.Игумнов собирал монгольские рукописи, материалы по этнографии, истории, праву и религии монгольских народов, а также эпос этих народов. Он собрал уникальную коллекцию монгольских книг и рукописей. Его перу принадлежит “Обозрение Монголии” - первое статистико-этнографическое обозрение. Е.Тимковский в своем описании путешествия в Китай привел различные сведения из работы А.В.Игумнова “О нынешнем состоянии Монголии”.

Большой интерес он проявлял к буддизму. Описал некоторые нормы обычного бурятского права. Как большой знаток права кочевых народов выступал как эксперт. По сведениям историка Л.М.Дамешка, в 1831 году управляющий делами Сибирского комитета Величко направил шесть частей проекта степных законов в Иркутск “на заключение известного знатока быта инородцев, губернского переводчика монгольского языка Игумнова”⁵.

В 20-х гг. XIX в. кафедры монгольского языка не имел ни один университет Европы. В России монгольским языком в это время занимался Я.И.Шмидт (1779-1847), монгольской историей – китаист Н.Я.Бичурин (1777-1853).

С 1827 года вопрос о создании кафедры монгольского языка стал обсуждаться в Казанском университете, ректором которого только что стал Н.И.Лобачевский-великий русский математик, человек широко

3. Кудрявцев Ф., Вендрих Г. Иркутск, 1971, с.83.

4. Щеглов И.В. Хронологический перечень важнейших данных из истории Сибири. 1032-1882 гг. Сургут, 1993, с.225.

5. Дамешек Л.М. Внутренняя политика царизма и народы Сибири. Иркутск, 1986. с.48.

и прогрессивно мыслящий. Было решено отправить двух студентов: О.М.Ковалевского и А.В.Попова— будущих профессоров монгольского языка, в Иркутск к А.В.Игумнову. Иркутский монголовед и переводчик дал свое согласие учить студентов и написал П.А.Словцову, инспектору сибирских училищ: “находясь на окончании дней жизни моей, с большою охотою берусь обучить монгольскому языку двух предлагаемых студентов и с этим вместе постараюсь сделать их же и полными наследниками того, что я по сей день приобрел, умею и знаю”⁶. О.М.Ковалевский называл А.В.Игумнова своим учителем, а себя его учеником.

А.В.Игумнов в течение многих лет работал над составлением монголо-русского словаря. Основой его составления были корни монгольских слов, было составлено четыре тома. Позднее он начал составлять словарь в алфавитном порядке, но не успел его закончить, успев составить только первый том.

Игумнов встретил О.М.Ковалевского и А.В.Попова в Иркутске приветливо. Ковалевский в одном из писем в Казань писал: “Для нас только, кажется, он хочет жить, с нами беседовать и сделать нас полными наследниками всего того, что в продолжение своей жизни приобрел и знает”⁷. Иркутский монголовед представил О.М.Ковалевскому и Попову в их распоряжение свои учебные рукописные пособия, часть которых была специально для них подготовлена. Особенно А.В.Игумнов выделял “Правила монгольского правописания”, изложенные в 3-х тетрадях: “Под сим простым заглавием заключается богатейшее собрание правил, касающихся не одного только правописания, но основательного познания изменений имен, спряжений глаголов, частиц отдельных, наречий и проч.”⁸.

В Рукописном отделе Вильнюсского университета находится часть материалов О.М.Ковалевского и среди них “Монгольский букварь”, составленный Игумновым и переписанный Ковалевским, по которому он начал изучать в Иркутске монгольский язык.

Находясь в Иркутске, будущие монголоведы начали под руководством Игумнова создавать свои словари, используя материалы четырехтомного неопубликованного словаря Игумнова. Для освоения переводов с монгольского на русский, они использовали монгольские и бурятские народные сказки, песни и легенды, в том числе и о Гэсэре, записанные Игумновым. Несомненно, что словарь Игумнова оказал существенную помощь Ковалевскому в составлении известного и не потерявшего своего научного значения “Монголо-русско-французского словаря” (1844-1849).

6. Шамо́в Г.Ф. Профессор О.М.Ковалевский. Очерк жизни и научной деятельности, Казань, 1983, с.26.

7. Там же, с.32.

8. Там же, с.72.

В письме О.Ковалевского в Казань от 26 ноября 1828 г. отмечается, что “преисполненный радости, в знак особенного расположения, подарил мне Монгольский словарь, или лучше сказать, материалы для составления его, тщательно им собранные с 1778 по 1824 год, в двух огромных томах. Сия рукопись содержит в себе одни Монгольские слова (около 12 000), с указанием откуда которое взято, и с объяснением труднейших выражений”⁹.

Летом 1829 г. Игумнов вместе с Ковалевским и Поповым выезжали в Забайкалье с целью практических упражнений в монгольском языке и сборе этнографических сведений о монголоязычных народах. В этой поездке они собрали значительное число старых монгольских рукописей или сделали копии с них, записали образцы бурятского и монгольского фольклора.

А.В.Игумнов записал для Ковалевского народное предание о происхождении бурят, которое тот позднее опубликовал в “Иркутских губернских ведомостях” (за 1869 г.), и “Казанском вестнике”. О.М.Ковалевский так написал об этом: “Переписали мы г. Игумнова два сочинения, из коих первое, под заглавием “О существовании бурятского народа”, включает в себе некоторые исторические сведения и местные предания о происхождении бурятов и присоединении их к России, а другое “Монгольское уложение”. Сочинение сие, по своей важности, служит дополнением материалов о ламской вере”. По сведениям современной исследовательницы творческого наследия Ковалевского О.Н.Полянской, сочинение Игумнова “О происхождении бурятского народа” пока не найдено¹⁰.

Подводя итоги поездки по Забайкалью в 1829 г., в письмах к М.Н.Мусину-Пушкину О.М.Ковалевский писал: “Между миссионерами (английскими) и Игумновым начались “ученые прения”, которые кончились в пользу англичан, “согласно с мнением лам”. Англичане отмечали “чистое произношение и бурятский разговор г. Игумнова, но не одобряют его переводов, уличают в незнании грамматики”¹¹.

На более поздних этапах обучения монгольскому языку, О. Ковалевский отмечает некоторые затруднения А. В. Игумнова в объяснении грамматических правил языка.

Тем не менее, позднее Ковалевский продолжил дело своего наставника А. Игумнова и составил современные грамматики, словари, хрестоматии монгольского языка, сохранил для науки накопленные знания.

В 1833 г. О. М. Ковалевский вернулся в Казань и организовал в университете первую в России кафедру монгольского языка, читал

9. Эпистолярное и дневниковое наследие монголоведа О.М.Ковалевского (1828-1833). Подготовка к изданию О.Н.Полянской. - Улан-Удэ, 2008, с.52

10. Полянская О.Н. Профессор О.М.Ковалевский и Бурятия. Улан-Удэ, 2001, с.23.

11. Там же, с.25

студентам лекции по монгольскому языку, литературе и истории Монголии публикует научные сочинения. В 1855 г. была учреждена кафедра монгольского и калмыцкого языков в Петербургском университете, которая стала центром монголоведческих исследований. Дальнейшее развитие русского монголоведения связано с именами Г.Гомбоева, К.Ф.Голстунского, А.М.Позднеева, Б.Я.Владимирцова, В.Л.Котвича, В.В.Бартольда. И расцвет этой ветви русской науки был бы немыслим без глубоких корней, большой, но незаметной подготовительной работы на ее ниве многих почти забытых ныне скромных тружеников, в том числе и работавшего в Иркутске А.В.Игумнова.

Судьба рукописей и книг А.В.Игумнова до сих пор полностью не ясна. По сведениям, приводимым академиком Ц.Дамдинсүрэнгом в хронологической таблице второго тома "Русско-монгольского словаря" (Улан-Батор, 1969) отмечается, что в 1838 году, монгольские книги, которые собрал переводчик А.В.Игумнов, при посредничестве П.Л.Шиллинга были переданы в библиотеку Петербурга.

Исследователь монгольских рукописей и ксилографов в Петербурге Л.С.Пучковский уточняет, что именно в это время в Азиатский музей была передана коллекция монгольских рукописей, купленная у А.В.Игумнова и имеющая его собственноручные пометки. Они образовали 6 коллекцию Собрания монгольских рукописей и содержат 166 единиц хранения.

Л.С.Пучковский считал, что рукописи монгольской грамматики и монголо-русского словаря А.В.Игумнова не сохранились. Последующие архивные изыскания опровергли эти сведения. Ученый из Казани Г.Ф.Шамов, автор подробной биографии О.М.Ковалевского обнаружил "Монгольский букварь" в Вильнюсе, а монголо-русский словарь обнаружил в Кяхте московский Китаист А.Н.Хохлов.

Иркутский историк З.Т.Тагаров обнаружил в Государственном архиве Иркутской области и описал рукопись рецензии А.В.Игумнова (на 67 листах) на перевод Я. Шмидта "Нового завета"¹². В научной библиотеке Иркутского госуниверситета хранится перевод на монгольский язык "Устава 1822 г.", осуществленный Игумновым и Санжихаевым.

Творческая биография и научное наследие А.В.Игумнова заслуживает специального монографического исследования.

12. Тагаров З. Т. Неизвестная рукопись А.В.Игумнова.

ЗОХИОГЧИД

Ж.Базарсүрэн. Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн. Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан. Профессор, доктор (Ph.D)

Г. Баярмаа. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн докторант

Д.Баярсайхан. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (DPhil)

Ч.Дашдаваа. Улаанбаатар их сургуулийн профессор, доктор (Sc.D)

Т.Етекбай. Керей-Ители, Эдийн засгийн ухааны магистр.

Ёшида Жүн-Ичи. Япон улс, Васэда их сургуулийн хүндэт профессор.

Ю.В.Кузьмин. ОХУ, Эрхүү хотын Байгалийн эдийн засаг, эрхзүйн их сургуулийн гавьяат профессор, (Sc.D)

Харнууд З. Лонжид. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Нарангэрэл. БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн профессор, доктор (Ph.D)

Д.Наранжаргал. БНХАУ, Өвөр Монголын их сургуулийн докторант.

Цонгоол Б.Нацагдорж. ШУА-ийн Түүхийн хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан.

Г.Түмэнбаяр. МУИС-ийн НШУС-ийн Түүхийн Тэнхимийн докторант

Б.Чинзориг, Хатагин. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

Л. Чулуунбаатар. МУИС, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

М.Энхбаатар. МУИС-ийн НШУС-ийн Түүхийн Тэнхимийн докторант